



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаас бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 сарын 21-ний өдрийн 389 тоот тогтоол, Монгол улсын Сангийн яамны 2014 оны 10 сарын 23-ны өдрийн 7-2/5791 албан тоот, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 8.10.11-р заалт, "Бүртгэлийн журам"-ын 10.3-р заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хавсралтад тусгасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 1,000,000 ширхэг буюу 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны жагсаалтанд бүртгэсүгэй.
2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д үнэт цаас хадгалуулах мэдэгдэл хүргүүлэхийг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-д даалгасугай.
3. Энэхүү тушаалаар бүртгэгдсэн Засгийн газрын үнэт цаасыг олон нийтэд арилжихтай холбоотой бэлтгэл ажлыг хангаж, арилжааг зохион байгуулахыг Дэд захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чингүнжав/, Мэдээлэл технологийн алба /З.Батгэрэл/-д үүрэг болгосугай.
4. Засгийн газрын бонд бүртгэгдэн, арилжихтай холбоотой мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО,
ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ №1096**

Хэнд: “Үнэт цаасны төлбөр
тооцоо төвлөрсөн
хадгаламжийн төв” ХХК-д

Огноо: 2014/10/29

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС ХАДГАЛУУЛАХ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас хадгалуулах тухай
Үндэслэл:	Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 сарын 21-ний өдрийн 389 тоот тогтоол, Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын 2014 оны 10 сарын 23-ны өдрийн 169 тоот тушаал
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Засгийн газрын үнэт цаас
Үнэт цаасны нэр:	ЗГЭБ-Б-12-274
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	1 000 000
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100 000
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	100 000 000 000
Үнэт цаасны хүү/өгөөжийн хувь хэмжээ:	15.795 %
Үнэт цаасны хугацаа: / долоо хоног/	12
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа: /давтамж/	Хямдруулалттай

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР